

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН
АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2023/25-15-ШТА-ГА

ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор **Ц.Өсөхбаяр**
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер **Т.Хонгорзул**
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор **Г.Шижирболд**
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор **Т.Хишигбат**
Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn
Аудитор **Э.Бат-Эрдэнэ**
Утас: 70533552 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
БҮЛЭГ А. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ОРОН НУТАГТ ШИНЭЭР АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.....	5
А.1 Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна.....	5
А.2 Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлүүдийг зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлт хэвийн байна.....	6
БҮЛЭГ Б. ТУСЛАМЖААР ОЛГОСОН МАЛЫН ТЭЖЭЭЛИЙГ ТОГТООСОН ХУГАЦААНД НЬ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	11
Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.....	11
Б.2 Тэжээлийн тусламжийг төлөвлөсөн хугацаанд нь орон нутагт нийлүүлж, малчдад олгосон байна.....	12
БҮЛЭГ В. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	13
В.1 Арилжааны банкаар дамжиж олгогдсон зээлийн үр дүнд төслийн нэгжээс хяналт хийгээгүй байна.....	13
ДҮГНЭЛТ.....	14
ЗӨВЛӨМЖ.....	15
ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	16
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
ЯОУХАБ	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
БНБУ	Бүгд найрамдах Беларусь улс
ХХК	Хариуцлагат хувьцаат компани

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Өмнөговь аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд	4
Хүснэгт 2	Тэжээл тараалт хийсэн мэдээлэл	11
Зураг 1	Беларусь-320.4 трактор	7
Зураг 2	Хаан хүнс ХХК Өмнөговь салбар	8
Зураг 3	Сүүний үйлдвэрийн барилга	8
Зураг 4	Өнөд өвлөх трейд ХХК махны үйлдвэр	9
Зураг 5	Тэжээл тараалт	12
Зураг 6	Тэжээл аппликейшн	12

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн.

Аудитын зорилго, хамарсан хүрээ

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх.

Аудитад Өмнөговь аймгийн ХХААГ, аймаг, сумдын ЗДТГ, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Өрийн удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны урт хугацааны хөгжлийн бодлого,
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа,
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат, Э.Бат-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатыг 2023 оны 05 дугаар сарын 21-ны өдрөөс эхэлж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 8 дугаар сарын 11-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан баталгаажуулж 08 дугаар сарын 18-нд УАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл:

Өмнөговь аймагт 2016-2022 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЯОУХАБ /ЖАЙКА, Бүгд Найрамдах Беларусь Улсын хөгжлийн банкны дамжуулан зээлдүүлэх төслүүдээс 5 зээл, 1 тусламж нийт 6 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Үүнд:

Хүснэгт: №1 Өмнөговь аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд:

N	Эх үүсвэр	Он	Төслийн нэр	Зориулалт	Мөнгөн дүн /сая.төг/	Төрөл	Дууссан эсэх
1	БНБУ-н хөгжлийн банк	2022	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх	59.1	Зээл	Тийм
2	Азийн хөгжлийн банк	2021	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Өмнөговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх	26.6	Зээл	Тийм
3	Азийн хөгжлийн банк	2021	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	3,038.2	Зээл	Үгүй
4	Азийн хөгжлийн банк	2022	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	3,300.0	Зээл	Үгүй
5	ЯОУХАБ /ЖАЙКА	2021	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх	510.0	Зээл	Үгүй
6	Дэлхийн банк	2021	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Аймгийн өвөлжилт хүндэрсэн 10 сумын малчин өрхүүдэд 1,045,000 кг тэжээл нийлүүлэх	1,226.8	Тусламж	-

БҮЛЭГ А. ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ОРОН НУТАГТ ШИНЭЭР АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.

А.1 Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна.

А.1.1 Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна.

Өмнөговь аймагт Беларусь улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжсэн “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийн хүрээнд 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А нийт 59.1 сая төгрөгөөр 100 хувийн төлөлтөөр Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 2021 онд “Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс, Хүрмэн сумдын нутагт бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх” 26.6 сая төгрөгийн, Улаанбаатар хотын Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл”-ээс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр Хаан хүнс ХХК 3,038.2 сая төгрөгийн, 2022 онд сүүний чиглэлээр Солид партнерс ХХК 3,300.0 сая төгрөгийн зээлүүд олгогджээ.

Япон улсын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай” төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Худалдаа хөгжлийн салбар банкаар дамжуулан “Мах, дайвар бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулах” чиглэлээр Өнөд өвлөх трейд ХХК 510.0 сая төгрөгийн зээлийг олгожээ.

Эдгээр төслүүд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл тогтвортой хөдөө аж ахуйн зорилтуудтай тус тус нийцсэн байна.

А.1.2 Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнд зээлүүдийг олгосон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А-238 дугаар тушаалаар Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А-ыг хуваарилсан байна. Хуваарилагдсан трактор, хөдөө аж ахуйн техникүүдийг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар худалдан авах гэрээг 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдөр байгуулж хүлээн авсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А-61 дүгээр тушаалаар “Өмнөговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх” ажлын худалдан авах ажиллагааг ХХААХҮЯ-наас зохион байгуулжээ.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр Хаан хүнс ХХК, сүүний чиглэлээр Солид партнерс ХХК-д

Улаанбаатар хотод байрлах Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан олгосон байна. Арилжааны банкнаас иргэн, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн төслийг үнэлж, сонгон шалгаруулсан байна.

Монгол Улсын Сангийн яам болон Худалдаа хөгжлийн банкны хооронд байгуулсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах Хоёр үе шаттай зээлийн төсөл”-ийн хүрээнд Худалдаа хөгжлийн банкны Өмнөговь салбараар дамжуулан Өнөд өвлөх трейд ХХК-д зээл олгосон байна.

А.2 Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлүүдийг зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлт хэвийн байна.

А.2.1 Зээлийн хөрөнгийг ашиглагч нар гэрээнд заасан үүргээ хугацаанд биелүүлсэн байна.

Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А-ыг аймгийн Засаг даргын 2022 оны 91 дугаар захирамжийг үндэслэн тухайн оны 02 дугаар сарын 17-ны өдөр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дансаар Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дансанд төлбөр болох 59.1 сая төгрөгийг шилжүүлэн гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хаан хүнс ХХК 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Улаанбаатар хотын Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан 3,038.2 сая төгрөгийг 7 жилийн хугацаатай 8 хувийн хүүтэй зээл авсан байна. Зээлдэгч зээлийн гэрээний 4.2-т заасан “Тэмээний мах боловсруулах үйлдвэр” Өмнөговь аймагт байгуулах зориулалтын дагуу ашиглаж, зээлийн эргэн төлөлтийг хэвийн хийж байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Солид партнерс ХХК 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотын Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан 3,300.0 сая төгрөгийг 7 жилийн хугацаатай 8 хувийн хүүтэй зээл авсан байна. Зээлдэгч зээлийн гэрээний 4.2-т заасан “Монгол тэмээ” төслийн хүрээнд сүүний үйлдвэр, ферм Өмнөговь аймагт байгуулах зориулалтын дагуу ашиглаж, зээлийн эргэн төлөлтийг хэвийн хийж байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах Хоёр үе шаттай зээлийн төслийн хүрээнд Худалдаа хөгжлийн банкны Өмнөговь салбараар дамжуулан 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Өнөд өвлөх трейд ХХК 8 жилийн хугацаатай 8 хувийн хүүтэй зээл авсан байна. Зээлдэгч зээлийн гэрээний 4.2-т заасан “Мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр” байгуулах зориулалтын дагуу ашиглаж, зээлийн эргэн төлөлтийг хэвийн хийж байна.

А.2.2 Төслийг хэрэгжүүлэгчдийн борлуулалтын орлого өссөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авсан Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А-ыг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар бүртгэлд тусгаж авсан байна.

Хүнс, Хөдөө аж ахуйн газар тус трактор, тоног төхөөрөмжийг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр иргэн Ж.Долгорсүрэнтэй 5 жил ашиглуулах гэрээ байгуулж хүлээлгэн өгсөн байна. Гэрээний 3.7-д “Ашиглагч нь газар тариалан эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ

үзүүлэх” гэж заажээ. Хөнгөлөлттэй нөхцөл гэсэн тодорхой бус тариф тогтоосон байгаа нь газар тариалан эрхлэгчдэд ялгавартай үнээр үйлчлэх эрсдэлтэй байна. Мөн 2022 оноос хойш хэдэн газар тариалан эрхлэгч, га талбайд ашигласан талаарх нотлох баримт байхгүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох боломжгүй болгож байна. Иймд энэ зөрчлийг арилгах талаар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт зөвлөмж өгч ажиллаа.

Дүрслэл №1 “Беларусь-320.4 трактор”



“Өмнөговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх” ажлын хүрээнд Усны эрэл хайгуул, үйлдвэр үйлчилгээний Эрдэнэдрийлинг ХХК Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс, Хүрмэн сумдын 20 бэлчээрт хайгуул хийж уст цэг тогтоосон тайланг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хаан хүнс ХХК “Тэмээний мах боловсруулах үйлдвэр” Өмнөговь аймагт байгуулах зориулалтаар зээлийг 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдөр авсан.

“Хаан Хүнс” компани 2002 онд байгуулсан хагас боловсруулсан бууз, баншны зах зээлийг шинээр бий болгож хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлээр Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Зээлийн санхүүжилтээр Даланзадгад суманд байрлах хуучны өлөн боловсруулах үйлдвэрийн барилга байгууламжийг худалдан авч олон улсын стандартад нийцсэн үйлдвэр болгохоор 2 үе шаттай засварын ажил хийж, төвийн дулааны шугамд холбож үйлдвэрийн байрыг байгуулж Өмнөговь аймагт салбараа нээсэн байна.

Өмнөговь аймаг дахь Мах бэлтгэх үйлдвэрийн үйл ажиллагааг 2022 оны 10-р сарын 20 өдрөөс эхэлсэн байна. Үндсэн үйл ажиллагаа нь гэрээт бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан тэмээний гулууз махыг олон улсын болон үндэсний стандартын дагуу эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага нийцсэн орчинд хэсэглэн ангилж, савлан Хаан хүнс ХХК-ны Улаанбаатар хот дахь мах бэлтгэх цехэд нийлүүлдэг байна.

Дүрслэл №2 Хаан хүнс ХХК Өмнөговь салбар



Өмнөговь салбар нь 2023 оны 7 дугаар сарын байдлаар MNS ISO 22000:2019 стандартыг мах бэлтгэх цехийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн шинээр 11 ажлын байр бий болгон ажиллаж байна. Нэг сард 100-120 тэмээний гулууз мах бэлтгэх, өдөрт 2,1 тонн мах ангилж савлах хүчин чадалтай, 7 тонн мах хөлдөөх, 60 тонн мах хадгалах 240 м.кв талбай бүхий 5 хөргүүр ажиллаж байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс Сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Солид партнерс ХХК “Монгол тэмээ” төслийн хүрээнд сүүний үйлдвэр, ингэний ферм Өмнөговь аймагт байгуулах зориулалтаар зээлийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр авсан.

Зээлийн санхүүжилтийг 2500 тэмээ худалдан авч уламжлалт болон эрчимжүүлсэн ферм, Тэмээний сүүг боловсруулан экспортод гаргах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүү боловсруулах үйлдвэр байгуулахад зарцуулахаар төсөлд тусгажээ.

Дүрслэл №3 Сүүний үйлдвэрийн барилга





Зээлийг 2023 оны 7 дугаар сарын байдлаар тоног төхөөрөмж болон үйлдвэрийн барилга барих ажилд зарцуулсан байна. Төслийн ажлын гүйцэтгэл 75 хувьтай үргэлжилж байна. Өмнөговь аймагт төсөл хариуцсан нэг ажилтанд ажлын байр шинээр бий болсон, үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах Хоёр үе шаттай зээлийн төслийн хүрээнд Худалдаа хөгжлийн банкны Өмнөговь салбараар дамжуулан Өнөд өвлөх трейд ХХК 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах зорилгоор зээл авсан.

Өнөд өвлөх трейд ХХК нь 2018 онд байгуулсан мах боловсруулах, ангилан савлах чиглэлээр Өмнөговь аймгийн Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байна.

Зээлийн санхүүжилтээр өөрийн хөрөнгөөр эхэлсэн үйлдвэрийн барилгыг ашиглалтад оруулж, 15 нэр төрлийн тоног төхөөрөмж, хөргүүртэй тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.

Өмнөговь аймгийн Даланзадгад суманд Өнөд өвлөх трейд ХХК-ны Даланбулаг махны үйлдвэрийн үйл ажиллагаа 2022 оны 10 дугаар сарын 29-ны өдрөөс эхэлсэн байна. Үндсэн үйл ажиллагаа нь орон нутгийн хэрэглэгч, уул уурхайн компаниудыг эрүүл ахуйн шаардлага хангасан дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр ханган ажилладаг байна.

Дүрслэл №4 Өнөд өвлөх трейд ХХК махны үйлдвэр





2023 оны 7 дугаар сарын байдлаар үйлдвэр бүтэн хүчин чадлаараа ажиллаж шинээр 12 ажлын байр бий болгосон байна. Нэг сард 20-21 тонн хонь, үхрийн мах бэлтгэх, ангилж савлах хүчин чадалтай үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр ашиглалтад орсноор орон нутгийн хэрэглэгчид, Оюу толгой ХХК болон бусад уул уурхайн компаниудад эрүүл ахуйн баталгаатай мах болон дайвар бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна.

Өнөд өвлөх трейд ХХК 2022-2023 оны өвөл аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж 100 тонн нөөцийн мах бэлтгэн орон нутгийн хэрэглэгчдэд хямд үнэтэй махаар үйлчилсэн байна. Компанийн борлуулалтын орлого 2021 онд 1,455.7 сая төгрөг байсан бол 2 үйлдвэр ашиглалтад орсноор 2023 оны эхний хагас жилд 1,227.0 сая төгрөг байна.

БҮЛЭГ Б. ТУСЛАМЖААР ОЛГОСОН МАЛЫН ТЭЖЭЭЛИЙГ ТОГТООСОН ХУГАЦААНД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.

Монгол Улсын Засгийн газар болон Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (Дэлхийн банк) нарын байгуулсан Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтийн хэлэлцээрээр “Болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсэг”-ийг шаардлагатай үед нь хүлээн авагч буюу Монголын Улсын Засгийн газрын хүсэлтээр 2 тал харилцан тохирч идэвхжүүлэх, тухайн бүрэлдэхүүн хэсэгт шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авагч тал зориулалтын дагуу зарцуулахаар тохирсон байна.

Засгийн газраас 2020-2021 оны өвөлжилт хүндрэх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 12-р сарын 16-ны өдрийн 213-р тогтоолоор Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн “Болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсэг”-ийг идэвхжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах, төслийн эх үүсвэрээс Өмнөговь аймгийн 10 сумын малчин өрхүүдэд 1,045 тонн тэжээл үнэ төлбөргүй /тусламжаар/ олгохоор болсон байна.

Энэ нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2/4 дугаар тогтоолоор баталсан “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт, арга хэмжээг дэмжсэн байна.

Хүснэгт №2 Тэжээл тараалт хийсэн мэдээлэл

№	Сумдын нэр	Малчин өрхийн тоо	Малчдад тараасан тэжээл, кг
1	Баяндалай	432	111,360
2	Булган	396	104,400
3	Гурвантэс	620	160,320
4	Мандал-овоо	347	94,560
5	Ноён	270	68,400
6	Сэврэй	379	95,040
7	Ханхонгор	545	137,520
8	Хүрмэн	385	99,360
9	Цогт-Овоо	335	88,800
10	Даланзадгад	308	84,280
11	Албан байгууллагын малчид		960
	Нийт	4,017	1,045,000

Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар тушаалын дагуу 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор статистикийн мэдээллийн санд бүртгэгдсэн малчин өрхөд тэжээл олгох ажлыг зохион байгуулж нийт 1045,0 тонн хүчит тэжээлийг “Баялаг фийд” ХХК-аас нийлүүлсэн байна.

Тусламжийн тэжээлийг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар хүлээн авч санхүүгийн тайлангийн бараа материал дансанд орлого зарлагаар тусгасан байна.

Дүрслэл №5 Тэжээл тараалт




Б.2 Тэжээлийн тусламжийг төлөвлөсөн хугацаанд нь орон нутагт нийлүүлж, малчдад олгосон байна.

Малчин өрхөд олгох нийт 1045,0 тонн хүчит тэжээлийг “Баялаг фийд” ХХК-аас аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар 24 удаагийн татан авалтаар 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч дууссан байна.

Өмнөговь аймгийн өвөлжилт хүндэрсэн 10 сумын малчин өрхүүдэд “Тэжээл” аппликейшн ашиглан тэжээлийн олголт хийсэн байна.

Дүрслэл №6 Тэжээл аппликейшн



Энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр өвөлжилт, хаваржилтын хүндрэлд өртөн зүй бусаар хорогдох эрсдэлтэй байсан малын тоог бууруулж тухайн малчин өрхөд учрах эдийн засгийн хохирлыг багасгасан байна.

Өмнөговь аймаг 2021 онд 2.5 сая толгой мал тоолуулж байсан бол өвөлжилт хүндэрсэн ч 2022 онд 2.6 сая толгой мал тоолуулан малын тоо толгой 0.12 хувиар өсөж тусламжаар олгосон тэжээл үр өгөөжөө өгсөн байна.

БҮЛЭГ В. ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Арилжааны банкаар дамжиж олгогдсон зээлийн үр дүнд төслийн нэгжээс хяналт хийгээгүй байна.

Хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг ХХААХҮЯ-ны цахим хуудсаар мэдээлсэн байна. Төслийн хөрөнгийн санхүүжилт зарцуулалтыг яамны шилэн дансанд байршуулсан байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 2021 онд “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл”-ээс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр Хаан хүнс ХХК 3,038.2 сая төгрөгийн, 2022 онд сүүний чиглэлээр Солид партнерс ХХК 3,300.0 сая төгрөгийн, Япон улсын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай” төслийн хүрээнд “Мах, дайвар бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулах” чиглэлээр Өнөд өвлөх трейд ХХК 510.0 сая төгрөгийг Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан зээлсэн.

Хөрөнгийн ашиглалтын талаар Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10 дахь хэсгийн 10.3 “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зээлийн гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, байнгын дотоод хяналт тавьж Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад тайлагнана” гэж заасан ч ХХААХҮЯ-аас хяналт хийгээгүй байна.

Тусламжийн тэжээлийг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар хүлээн авч малчин өрхүүдэд тараалт хийсэн тайланг цаасаар 7 хоног бүр ХХААХҮЯ-нд мөн “Тэжээл” аппликейшнаар хянуулж ажиллажээ. Тэжээлийн үр дүнг ХХААХҮЯ-аас хараат бус байгууллагаар “Дунд хугацааны үнэлгээ” хийлгэсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна.
- Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлүүдийг зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлт хэвийн байна.
- Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.
- Тусламжаар олгосон малын тэжээлийг тогтоосон хугацаанд нь зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Тэжээлийн тусламжийг төлөвлөсөн хугацаанд нь орон нутагт нийлүүлж, малчдад олгосон байна.
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Арилжааны банкаар дамжиж олгогдсон зээлийн үр дүнд төслийн нэгжээс хяналт хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргад:

1. “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийн хүрээнд 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А-уудыг ашиглуулах гэрээг шинэчлэн байгуулах
2. Хөнгөлөлтэй үнээр үйлчлэх тарифыг зах зээлийн үнийг судлан шинэчлэн тогтоож байх
3. Үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, хяналт тавих.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 30-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

8 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46089

Утас: (976) 7053-2393, Факс: (976) 7053-2180

Цахим шуудан: umnugobi_hhaagdug@yahoo.com

Цахим хуудас: www.hhaa.om.gov.mn

2023.08.16 № 261

Табай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИЙН ГАЗАРТ

“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төсөлтэй тацилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ЗАХИРГАА, АЖ АХУЙН

АЛБАНЫ ДАРГА

Т. БАТЖАРГАЛ

1120070009 21 9048804

462303100

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/25

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

D:\2023 Он\Бичиг Хэрэг\А Тушаал\А-25.Doc

016010040